

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН
“ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛИЙН ОРДЫГ ДАЛД
АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.4. Төслийн хүчин чадал	4
1.5. Дэд бүтэц	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Байгаль орчны онцлог	5
2.2. Нийгэм эдийн засаг	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
3.1. Агаарын чанар	7
3.2. Хөрсөн бүрхэвч	7
3.3. Гадаргын болон газрын доорх ус	7
3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	8
3.5. Ургамлан нөмрөг.....	8
3.6. Амьтны аймаг	8
3.7. Нийгэм эдийн засаг	8
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	10
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	11
4.3. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	11
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	12
4.5. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	13
4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13
4.7. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
4.9. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	16
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	17
ДҮГНЭЛТ.....	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг	3
Зураг 2. Хүн амын тоо	5

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-16790А дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайн координат	3
Хүснэгт 2. Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ	6
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	9
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	11
Хүснэгт 6. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	11
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	12
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13
Хүснэгт 9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөгөө	16
Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	17

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Шианганюнтун” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9019029126
Регистрийн дугаар: 5165407
Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 40/4, 9 тоот
Холбоо барих утас: 99027966- Мөнхтамга

1.2. Төслийн зорилго

Холимог металлын ордыг далд аргаар байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай олборлож орон нутагт шинээр ажлын байр бий болгох, ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэргээр компаний эдийн засгийн чадварыг нэмэгдүүлэн, улсын болон орон нутгийн төсөвт тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулахад оршино.

1.3. Талбайн байршил

Цагаан толгойн холимог металлын орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумаас баруун хойш 25км зайд байрлах ба Улаанбаатар хотоос 280км, Мандалговь хотоос зүүн тийш 160км орчимд оршино. Орд нь 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-48 84 тоот хавтгайд ашигт малтмалын MV-16790А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 117.93 га талбайг хамарч байна.



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

Хүснэгт 1. MV-16790А дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайн координат

№	Уртгаг			Өргөрөг		
1	107	52	56	45	57	09
2	107	51	31.57	45	57	09
3	107	51	31.57	45	57	30
4	107	52	56	45	57	30

1.4. Төслийн хүчин чадал

Тус холимог металлын ордыг далд уурхайн аргаар 7 жил ашиглах бөгөөд жилд дунджаар 100.0 мян.тн хүдэр олборлон флотацийн аргаар баяжуулж жилд дунджаар 16.92 мян.тн хар тугалга, цайрын баяжмал борлуулна.

Далд уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагаас төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу дараах байдлаар авч байна. Үүнд:

- Жилийн хуанлын өдөр 365 хоног
- Баяр ёслолын үеийн амралтын өдөр 12 хоног
- Засвар үйлчилгээний өдөр 53 хоног
- Жилд ажиллах хоног 300 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг
- Долоо хоногийн ажлын хоног 7 хоног тус тус байна.

1.5. Дэд бүтэц

Усан хангамж: Баяжуулах үйлдвэрийн нийт хэрэгцээт усны 70%-ийг эргэлтийн усан хангамжаар шийдвэрлэх бөгөөд үлдсэн 30.0%-ийг далд уурхайгаас гарах шүүрлийн усаар хангахаар тооцоолсон байна. Баяжуулах үйлдвэрийн усан хангамж нь үйлдвэрлэлийн ба галын аюулаас хамгаалах усан хангамж, баяжуулах үйлдвэрийн эргэлтийн ус хангамж зэргээс бүрдэнэ.

Технологийн цэвэр усны хэрэгцээг $16.2:3.6=4.5$ л/сек-ийн ундрагатай усны эх үүсвэрээр хангана гэж тооцоолов. Далд уурхайгаас шавхаж буй усны хэмжээ $104\text{м}^3/\text{цаг}$ буюу 28.8 л/сек тул ус хэрэглээг бүрэн хангана.

Хог хаягдал: “Шианганюнтун” ХХК-д нийт 142 хүн ажиллах ба нэг хүнээс гарах хоногийн нийт хог хаягдлыг 0.3 кг-аар тооцсон. Хоногт 43 кг ахуйн хог хаягдал үүсэхээр байгаа ба үүнийгээ Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт ачиж зайлуулдаг байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

“Шианганюнтун” ХХК нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Хараат нэртэй газарт байрлах “Цагаан толгойн холимог металлын ордыг далд аргаар ашиглах” төслийг 117,93 га талбайд хэрэгжүүлж байна.

Далайн түвшнээс дээш 1100-1465 метр өргөгдсөн хайргархаг, шавранцар цайвар хүрэн, хужир шаварлаг элсэнцэр буюу хөнгөн шавранцар бор хөрс голлосон уул толгодлог гадаргатай. Тус газрын хөрсөнд агь, гашуу, ерхөг, хазаар, дэрс, таана, хөмүүл, хялгана голлон ургана. Чихэр өвс, царван, таван салаа, бажууна зэрэг эмийн ургамал, буйлс, хайлс, яргай, бургас, харгана зэрэг модлог ургамал ургана.

Дундговь аймгийн зүүн хэсэгт: Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төвөөс 150 км, Говьсүмбэр аймгаас 80 км, өөрийн аймгийн Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдтай, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг байна.

Агаарын дундаж температур өвөл 1-2 сард 30 хэм хүрч хүйтэрдэг. 7 сарын сүүлч 8 сар хүртэл зундаа 35 хэм хүрч халдаг эрс тэрс уур амьсгалтай.

2.2. Нийгэм эдийн засаг

1925 оны эхээр засаг төрийн шинэчилсэн зохион байгуулалтаар Сэцэн хан аймгийн Боржигон Сэцэн вангийн хошууны Догшин Гучит сумын Их догшин отгийг Хан хэнтий уулын аймаг, Оцол сансар уулын хошуу Баян жаргалан уулын сум гэж нэрлэн 1925 оны дөрөвдүгээр сард 5 баг, 200-аад өрх 1000 гаруй хүн амтай, 37819 толгой малтай байгуулагдсан байна.

Тус суманд 1925 онд Хөдөлмөрчдийн хурлын захиргаа, 1927 онд МАХН-ын үүр, 1928 онд малын эмнэлэг, 1937 онд эрүүл мэндийн төв, 1940 онд бага сургууль, 1960 онд холбооны салбар, 1965 онд хүүхдийн цэцэрлэг, 1956 онд ХАА-н нэгдэл, 1975 онд эмийн сан зэрэг байгууллагууд байгуулагдаж байжээ. Дундговь аймгийн Баянжаргалан сум нь 1924 онд байгуулагдсан. Хуучнаар Хан Хэнтий уулын аймаг Оцолсансарын уулын хошуу. “Шилийн гол”, “Энгэр-Ус”, “Аргатай” гэсэн 3 багийн нийт 409 өрхтэй, 1169 хүн суурьшдаг байна.



Зураг 2. Хүн амын тоо

Нөлөөллийн үнэлгээ нэгтгэл: “Цагаан толгой холимог металлын ордыг ил аргаар ашиглах” төсөлд хийсэн байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэх нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг. Энэхүү нэгтгэл нь БОННУ-ний үр дүнд үндэслэн эцсийн шийдвэрийг гаргах нөхцөлийг бүрдүүлдэг. Цагаан толгой холимог металлын ордыг олборлох төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүнгүүдийг нэгтгэн доорх хүснэгтэнд үзүүлэв.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН “ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ОРДЫГ” ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ				
	Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
Байгаль орчин					
Газарзүйн ландшафт	0	-2	-3	-2	0
Газрын гадарга ба газар доорхи ус	1	-1	-1	-2	0
Агаарын чанар	0	-1	-5	-3	
Хөрс	0	-1	-5	-2	-1
Ургамал	0	0	0	-3	-1
Амьтан	0	0	-4	-4	0
Нийт нөлөөллийн тоо	1	11.9	18	16	2
Эзлэх хувь	2.38		42.85	38.09	4.76
Нийгэм эдийн засаг					
Нутгийн оршин суугчид	0	0	-1	+3	0
Нийт нөлөөллийн тоо	0	1	1	4	0
Эзлэх хувь		16.7	16.7	66.6	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 14,28 хувь нь бага, 42,85% нь дунд зэрэг, 38,09 хувь нь их, 4,76% нь аюултай байна.				
	Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 66.6 хувь нь их, 16.7 хувь нь дунд зэрэг 16.7 хувь нь бага байна.				

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанар

- Тээврийн хэрэгслийн дуу чимээ, шуугиан орчны дуу чимээг нэмэгдүүлэх,
- Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдлаар агаар орчин бохирдох,
- Тээврийн хэрэгслээс тоосжилт үүсэх,

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн хорт хий ялгаруулалтыг MNS 5014:2009 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд нь барьж ажиллах, шаардлагатай бол утааны шүүлтүүр суурилуулах, галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох,
- Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж тоос болон бусад бохирдуулагч бодисын хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, агаарын бохирдолтыг хянах, MNS 4585:2016 стандартын ЗДХ-с давсан агууламж илэрсэн тохиолдолд тухай бүрт эх үүсвэрийг тогтоон бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хог хаягдлыг хаях зориулалтын дагуу байхаар зохион байгуулах,
- Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг цаашид бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх,

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Далд уурхайн болон баяжуулалтаас үүсэх ахуйн хог хаягдлын нөлөөгөөр талбайн өнгөн хөрс бохирдох,
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Хөрсөнд бохирдол нэвчихгүй байдлаар төлөвлөх,
- Хөрс бохирдохоос сэргийлэх, хатуу хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөлийг хангасан цэгт 3-с доошгүй ангилан ялгаж түр хадгалан, зөөвөрлөж тогтоосон цэгт зайлуулж байх,
- Бусад хог хаягдал болон бусад шингэн хаягдлыг хур борооны усаар зөөгдөхгүй байхаар төлөвлөх,
- Автомашины зогсоол, засварын талбайг хатуу хучилттай болгох,
- Тухайн талбайд хүнд элементийн бохирдол илрээгүй боловч цаашдын үйл ажиллагааны үед санаатай болон санамсаргүй байдлаар хөрсийг бохирдуулж болзошгүй. Хэрэв бохирдсон тохиолдолд нарийвчилсан судалгаа хийж бохирдлыг бууруулах, саармагжуулах арга замуудыг хэрэгжүүлэх,
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэж, аливаа газар ашиглалтын зөрчил илэрсэн тухай бүрд зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. Гадаргын болон газрын доорх ус

- Шингэн хаягдал зайлуулах шугамын бүтэн байдал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах
- Хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсөөр дамжин гүний ус нянгийн бохирдолтод өртөх

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ундны усанд усны чанарын химийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэж, MNS 0900:2018 стандартын шаардлагад нийцүүлэн ажиллаж,
- Төслийн хэмжээнд нийт ус ашиглалтад “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 30.1 дахь хэсгүүдийг хэрэгжүүлж ажиллах,
- Ундны усыг хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажилчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаж байх. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

3.5. Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тохижилтийн ажлын хүрээнд эзэмшил талбайн 20 хувьд ногоон байгууламж, тарималжуулалтын ажил хийх шаардлагатай байна.

3.6. Амьтны аймаг

Төслийн талбайн нь хүн ам суурьшлын бүсэд байрлалтай тул амьтад үргэж, дайжсан байдалтай байна.

- Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас амьтад муудсан хүнсийг идэж өвчлөх, үрэгдэх

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Төслийн талбай, түүний орчимд амьдардаг амьтдыг агнах, үргээх зэрэг санаатай үйлдэл гаргахаас сэргийлж байгууллагын дотоод журамд энэ талаар заалт тусган тогтмол зөвлөмж, анхааруулга өгч байх, шаардлагагүй нөхцөлд машин техникээс хүчтэй дуу чимээ гаргахгүй байхыг анхааруулах шаардлагатай.

3.7. Нийгэм эдийн засаг

- Иргэдийн амьдрах орчны тав тух алдагдахаас сэргийлж шөнийн цагаар 45 дБа илүү дуу чимээ гаргасан үйл ажиллагаа явуулахгүй байх,
- Ажилчдыг эрүүл шим тэжээллэг хоол хүнсээр хангах,
- Аюулгүй байдлыг хангах хувцас хэрэглэлээр тогтмол хангаж, хэрэглүүлэн, зөв хэрэглээний талаар дадлагыг тогтмол хийх,
- Үйл ажиллагааг зохих стандарт, хууль, журамд нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэн гэнэтийн аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэх, бэлэн байдалд үйл ажиллагааг явуулах,

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2025 онд мэргэжлийн эрх бүхий “Маргад Очирваань” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2025 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **22,512,500** төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Зардлын хэлбэр	2025 он
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,950,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	1,950,000
Ногоон байгууламжийн төлөвлөгөөний зардал	2,700,000
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	480,000
Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	240,000
Химийн бодисын эрлслийн менежментийн төлөвлөгөө	1,700,000
Орчны хяналт шинжилгээний зардал	2,090,000
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,402,500
НИЙТ	22,512,500

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч байршуулах байрлуулах	Агаарын чанар	ш	3	-	150.0	2025 онд	“Агаарын тухай хууль” “Агаар бохирдлын төлбөрийн тухай хууль” MNS 4585:2016 Авто тээврийн тухай хууль MNS 6278:2011 MNS 4597:2014 MNS 6056:2009 MNS 5973:2009 MNS 4598:2020
	Дотоод зам талбай, авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Төслийн талбай	-	200 м²	-	3 000.0	2025 онд	
	Үнс хадгалах хаягдлын цэгийг сайжруулах	Агаарын чанар	Удаа	1	-	400.0	2025 онд	
УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Усны нөөц	Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	Удаа	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		12 сард	“Усны тухай хууль” MNS 0899:2020 MNS 0900:2018 MNS 6561:2015
Усны тоолуур суурилуулах зөвлөмж	Усны нөөц хэмнэх	Худгийн байранд	Удаа	1	300.0		2025 онд	
Ахуйн хэрэглээний ус	Ажилчдын ундны усны зөөврийн савыг сонгохдоо хүнсний зориулалттай PET тэмдэглэгээ бүхий савыг ашиглах, жил бүр шинэчилж байх	Төслийн хэмжээнд	Удаа	1	500.0		2025 онд	
	Гүний худгийн хатуулагтай ус зөөлрүүлэгч төхөөрөмж суурлуулах зөвлөмж	Төслийн хэмжээнд	Удаа	1	1 600.0		2025 онд	
ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Ил задгай хог хаяснаар агаар орчин бохирдох, борооны усаар хөрсөнд нэвчиж газрын доорх ус, хөрсний чанарыг муутгах,	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч	тогтмол	тогтмол	Зардал тусгах шаардлагагүй		Төслийн хугацаанд	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт MNS 5924:2015

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН “ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ОРДЫГ
ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

халдварт өвчин үүсгэх							Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
Хөрсний эвдрэл элэгдэл	Төслийн талбайд ногоон байгууламж байгуулах, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх.	Ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч	Төсөл хэрэгжиж буй талбайд	-	Ногоон байгууламжийн зардалд тусгасан.	2025 онд	
УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ							
Мод тариалах	Ажилчдыг мод тариалах ажилд оролцуулах	Нийт ажилчид	-	-	Зардал тусгах шаардлагагүй	Намар	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авчх эрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Ургамал хамгааллын тухай хууль MNS 5918:2023
Төслийн талбайн ойр орчим бохирдох, ургамлан нөмрөг талхлагдах	Төслийн талбайн ойр орчмын цэвэрлэгээг тогтмол хийх	Талбайн ойр орчим	Удаа	Улирал бүр	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	
НИЙТ					5.950.000		

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Үйл ажиллагааны арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
MNS 6426:2013 стандартын 5.1.8 “Эдэлбэр газрын нийт талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламж тарималжуулалт хийх” шаардлагын дагуу ногоон байгууламж тарих	Суулгац тарихад шаардлагатай материал, хар шороо, бордоо авах	Ой, ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, агаарын чанар	тн	3	300.0	900.0	2025 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
Орчны тохижилтыг сайжруулан 11,7 га-д 5895 ширхэг суулгац тариалан дүйцүүлэх байдлаар тарималжуулах	Хайлаас		ш	600	2.0	1 200.0	2025 он	
	Хуайс		ш	120	5.0	600.0	2025 он	
Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал						2,700,000		

4.3. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 6. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН “ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ОРДЫГ
ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх хугацаа	Зардал, мян.төг	Хариуцах байгууллага
1	Орон нутгаас зохион байгуулж буй нэгдсэн цэвэрлэгээ, үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй хамрагдах	Нийгмийн хариуцлага, оролцоо нэмэгдэх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч
2	Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах	Аюулгүй ажиллагаа	Өдөр бүр	Зардал тусгах шаардлагагүй	
3	Шинээр ажлын байр бий болох тохиолдолд орон нутгийн иргэдийг авч, ажиллуулах	Ажилгүйдлийн тоо буурах, хөдөлмөрийн ур чадвар нэмэгдэх	Төсөл хэрэгжих хугацаанд	Хүний нөөцийн дотоод зохион байгуулалтад тусгах	
НИЙТ					-

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын төрөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хугацаа (2025 он)	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Ахуйн хатуу хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлын дээвэртэй түр цэг байгуулах. Энэ нь хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой байх, хаягжуулах	Ахуйн хог хаягдлын менежмент	Төсөл хэрэгжих хугацаанд	1 000.0	1 000.0	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2011 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4, 11 дүгээр 11.1, 11.2
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Зардал тусгах шаардлагагүй		
	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Хатуу хог хаягдлын цэгт	Тухай бүр	50.0	200.0	
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрд нь	Зардал тусгах шаардлагагүй		
	Дотор талбайд 3-с доошгүй төрлөөр ангилах хогийн сав байршуулах	Шалган нэвтрүүлэх болон анхны тусламжийн байранд	Төсөл хэрэгжихээс өмнө	100.0	200.0	
	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	Жилд 1 удаа	150.0	150.0	
Ахуйн шингэн хог хаягдал	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу хаягдал усны төлбөрийг татварын албанд төлж барагдуулах	Төслийн хэмжээнд	Шаардлагатай тухай бүрд	Гэрээний дүнгээр		
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах	Төслийн хэмжээнд	Удаа	400.0		
НИЙТ				1,950,000		

4.5. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хугацаа (2025 он)	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат						
ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, ХХД алдагдснаар ажиллансдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	ХБ-той ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хэрэгслээр бүрэн хангах	Ажлын байр	Төсөл хэрэгжих хугацаанд	1 200.0	1 200.0	“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 5029:2011 MNS 6458:2014 MNS /ISO/ 13688:2000
	Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилгаа, сургалт явуулах	Төслийн хэмжээнд	Тогтмол	500.0	500.0	
НИЙТ				1,700,000		

4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Шианганюнтун” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, ус, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, нөлөөллийг бууруулах, сааруулах үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх, төлөвлөхийн тулд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэх боломжтой бохирдлын эх үүсвэрүүд дээр тогтмол мониторингийн хэмжилт хийх шаардлагатай. Мөн цаашид тус төслийн үйл ажиллагаа болон ашиглалтын талбайн хэмжээ нэмэгдэхээр бол хяналт, мониторингийн цэгүүд нэмэгдэх боломжтой.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН “ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ОРДЫГ
ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.1	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO2, NO, NOX) Хүхэрлэг хий (SO2) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO2), CO, HCN, O2.	мкг/м3	Уурхайн суурин 1 цэг, тээврийн зам дээр 1 цэг, овоолго орчимд 1цэг Уурхайн олборлолт явуулах 1 цэг, ШТС 1 цэг, автозогсоол орчимд 1 цэг, хаягдлын сан 1 цэг, нөлөөлөлд өртөөгүй талбай 1 цэг Нийт 8 цэг		Жилд 1 удаа	90.0	720.0	Мэргэжлийн байгууллага	MNS 4585:2016 MNS 3384:1982 MNS 4048:1988 MNS 0017-2-5-11:1988 MNS 5013:2009 MNS 5014:2009 MNS 5002:2000
1.2	Агаарын тоос тоосонцор (PM2.5, PM10)	мкм			Жилд 1 удаа	40.0	320.0		
1.3	Цацрагийн хэмжилт, шинжилгээ хийлгэх	-	Зуухнаас гарах хаягдал үнснээс Хаягдлын сангаас Хүдрийн овоолгоос Нийт 3 цэгээс дээж авах	Жилд 1 удаа	45.0	270.0			
УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.1	- Усны хими, физикийн үзүүлэлт Микробиологийн үзүүлэлт - Хаягдлын сангаас дээж авах	мг/дм³ 1 мл-т илрүүлэх 100 мл-т	Гүний худаг, хаягдлын сан	2 дээж	Жилд 1 удаа	100.0	100.0*2 цэг*1 удаа= 200.0	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002 MNS 0900:2018
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.2.	- Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co, Cu/	мг/кг	Уурхайн суурин 1 цэг, тээврийн зам дээр 1 цэг, овоолго орчимд 1цэг Уурхайн олборлолт явуулах 1 цэг, ШТС 1 цэг, автозогсоол орчимд 1 цэг, хаягдлын сан 1 цэг, нөлөөлөлд өртөөгүй талбай 1 цэг Нийт 8 цэг		Жилд 1 удаа	47.5	47.5*8 дээж*1 удаа = 380.0	Хөрс, ус судлалын лаборатори	MNS 3298-90 MNS 2305:94 MNS 5850-2023 MNS 3310-91
2.3.	- Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд	мг/кг				25.0	25.0*8 дээж*1 удаа = 200.0		
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал							2,090,000 төгрөг		

4.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нэг жилийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ									
1		Ажилчдын дунд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн	Нийт ажилчид	Жилд 2 удаа	Үйл ажиллагааны зардлаар			10 сард	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШИАНГАНЮНТУН” ХХК-ИЙН “ЦАГААН ТОЛГОЙН ХОЛИМОГ МЕТАЛЛЫН ОРДЫГ
ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		авран хамгаалах сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар байршуулах						боловсруулах заавар, МУ-ын Шадар сайдын 120 тоот тушаал, 2018.12.07	
2	Гамшиг	Гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	-*-	Үйл ажиллагааны зардал			4-р улиралд	
3	Хүчтэй шороон болон цасан шуурга	Хог хаягдал хийсэхгүй байх нөхцөлийг хангасан хогийн төвлөрсөн цэгийг байгуулах	Хогийн цэг	1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан				Хог хаягдлын тухай хууль
4		Дуу цахилгаантай бороо орох үед ажилчид, техник хэрэгслийн үйл ажиллагааг түр зогсоох зэрэг эрсдэлийн үед өөрийгөө хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаар			Төсөл хэрэгжүүлэхээс өмнө	Гамшгийн тухай хууль
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ									
5	Ажилчид бэртэх	Ажилчдын ажлын байрны нөхцөлтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны, хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Нийт ажилчид	-*-	Үйл ажиллагааны зардлаар			Жилд 1 удаа	ХАБЭА-н бодлого, заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль
		Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах						Жилд 1 удаа	
		Дархлаа дэмжих, хор саармагжуулах эрүүл ахуйн шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах						Өдөр бүр	
6	Гал түймэр	Гал гарч болзошгүй объектуудын ойролцоо ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглох, хянах	Ажилчдын байр, агуулахын гадна	-*-	-			2025 онд өдөр тутамд	Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам, галын аюулгүй байдлын тухай хууль
		Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах, хугацаа дууссан тухай бүр шинэчлэх						2 иж бүрдэл	
		Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж аймгийн онцгой байдлын албаар батлуулах		4 ш	Галын хор цэнэглэх-30.0	120.0	120.0	2025 он	
		Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж аймгийн онцгой байдлын албаар батлуулах	Ажилчид, төслийн талбай	-*-	Зардал шаардахгүй			Төсөл хэрэгжүүлэхээс өмнө	
		Галын аюулгүй байдлын дүгнэлтийг онцгой байдлын газраар гаргуулах	Аялал жуулчлалын бааз	1	200.0	200.0	200.0	Жилд	
		Ажилчдад галын аюулын үед авах арга хэмжээний талаарх сургалтыг явуулах	Нийт ажилчид	-*-	ХАБЭА-н сургалт, сурталчилгааны зардлаар			2-р улиралд	
Нийт зардал						480,000			

4.8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Нөхөн орлуулж хамгаалахаар тогтоогдсон нутагт газар сонгох	Экологийн хувьд ижил төсөөтэй нутаг сонгох	Удаа /намар/	7,402,500		Жил бүрийн 12.20 дотор	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31дүгээр зүйл “Байгалийн ургамлын тухай” хуулийн 7 дугаар зүйл
НИЙТ					7,402,500		

4.9. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян. төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Хариуцаж зохион байгуулах албан тушаалтан
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Төслийн хэмжээнд	Удаа/ жилд	1	Хариуцсан ажилтан		Жил бүрийн 12.20 дотор	Байгаль хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль БОАЖ-ын сайдын 2019.10.29–ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам” Усны тухай хууль
2	Ус ашигласны төлбөр	Усны нөөц, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Сар бүр	1 жилд 12 удаа	Ус ашиглуулах гэрээний дүнгээр, тоолуурын заалтаар		2025 он	
3	Ажлын байранд эмийн сан бий болгох		ш	3	80.0		240.0	
4	Хүрээлэн буй орчноо хамгаалах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж бүхий сургалт зохион байгуулах	Экосистем, эрүүл ахуй, ёс зүй	Удаа/жилд	1	Дотоод үйл ажиллагааны хүрээнд	Жилд	2025 онд	
НИЙТ							240,000	

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах газар	Хариуцаж зохион байгуулах албан тушаалтан
1	Байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ийн биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сард багтаана.	Үйл ажиллагааны зардалаар	Сумын байгаль орчны газар	Удирдлага Ерөнхий инженер Хариуцсан ажилтан
2	Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт зохион байгуулах	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор		Баянжаргалан сум	
3	Орон нутаг, төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тайлан, төлөвлөгөөг www.eic.mn цахим хэлбэрээр	Төлөвлөгөөг хянуулан батлуулах	12-р сарын 10-ний дотор		Улаанбаатар	

ДҮГНЭЛТ

“Шианганюнтун” ХХК нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт “Цагаан толгойн холимог металлын ордыг далд аргаар ашиглах” төсөл үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хүрээнд 2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **22,512,500 төгрөг** ба үүнд 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа зэрэг ажлын зардлууд багтсан болно.